

**“МОНГОЛ УЛСЫГ 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН
ҮНДСЭН ЧИГЛЭЛ”-ИЙН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ,
ХҮРЭХ ТҮВШИНД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАНИЛЦУУЛГА**

2024 оны 12 дугаар сарын 24-ны өдөр

НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО

Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго нь Монгол Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшинд Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын эрхлэх асуудлаар тусгагдсан шалгуур үзүүлэлтийг хяналтад авч, гүйцэтгэлийн хүрсэн түвшинг зорилтот түвшинтэй нь харьцуулан үр дүнг үнэлэх, дүгнэлт, зөвлөмж гаргах, зорилтот түвшинд хүрэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино.

ХОЁР. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ АРГА ЗҮЙ

Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшинд Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын эрхлэх асуудлаар тусгагдсан шалгуур үзүүлэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, Монгол Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин, Засгийн газрын 2020 оны 203 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт болон Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг тус тус удирдлага болгов.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин”-д туссан суурь түвшин, Засгийн газрын 2020 оны 203 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин”-д туссан 2024 оны зорилтот түвшинтэй хүрсэн түвшинг харьцуулан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.2.1 болон 6.2.2 дах заалтын аргачлалыг хослуулан тооцсон болно.

ГУРАВ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН

Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшинд Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын эрхлэх асуудлаар 3 шалгуур үзүүлэлт туссан ба тэдгээрийн гүйцэтгэлийн хүрсэн түвшинг зорилтот түвшинтэй нь харьцуулан хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнг дараах хүснэгтэд харуулав.

№	Шалгуур үзүүлэлт	Үнэлгээ (хувь)
1.	Уул уурхайн салбарын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	32.7
2.	Боловсруулах аж үйлдвэрийн салбарын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	30.0
3.	Гол нэр, төрлийн шатахууны хэрэгцээг Евро 5 стандартад нийцүүлэн дотоодоос хангах хувь	31.4

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ

Дээрх 3 шалгуур үзүүлэлтийн суурь түвшинг “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин”, Засгийн газрын 2020 оны 203 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтэд туссан 2024 онд хүрэх түвшингийн хувиар тооцож хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нь учир дутагдалтай байна.

Тухайлбал, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин”-д “Боловсруулах аж үйлдвэрийн салбарын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь”-д шалгуур үзүүлэлтийн суурь түвшинг 10.9 хувь гэж заасан байхад Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин”-д “Боловсруулах аж үйлдвэрийн салбарын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь”-д шалгуур үзүүлэлтийн суурь түвшингийн 2024 оны зорилтот түвшинг 10.0 хувь гэж заасан тул утгын зөрүүтэй байна.

ТАВ. САНАЛ, ЗӨВЛӨМЖ

Хяналт-шинжилгээ, үнэлгээг бодитой болгож, шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшинг зөв тодорхойлохын тулд “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтийг тодорхой болгох шаардлагатай байна.

ХЯНАСАН:
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД
АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА

Б.ӨНӨМӨНХ

БОЛОВСРУУЛСАН:
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД
АУДИТЫН ГАЗРЫН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Б.БАТТУУЛ